



УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.



Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн хэвийн, зарим ажлын чанар шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

2016 оны 04 сар

УВААГ-2016/01-ГА

УВААГ-2016/01-ГА

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд	Товчилсон үгийн тайлал	4
Аудитын менежер Ж.Энхжаргал	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-6
Ахлах аудитор С.Алтанхундага	Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна	7
Ахлах шинжээч М.Батсуурь	1.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулсан байна.	7-9
Аудитор Т.Намжил С.Батсайхан	1.2. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зураг төсвийн өртгөөс нь бага төсөв батлагдсан байна.	9
Шинжээч Я.Зунгарав	Дүгнэлт	10
2016 оны 4 дүгээр сар	Зөвлөмж	10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 7045-3721, 7045-4721, 70453799 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг 2. Худалдан авах ажиллагааны алба худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулжээ.	10
	2.1. Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтыг бүрэн хангасан байна.	10-11
	2.2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.	11
	Дүгнэлт	12
	Бүлэг 3. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.	12
	3.1. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гэрээний дагуу олгоогүйгээс хугацаа хэтэрсэн байна.	12-14
	3.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавьсан хэдий ч зарим ажлын чанар хангалтгүй, данс бүртгэлд тусгаагүй байна.	14-20
	Дүгнэлт	20
	Зөвлөмж	20
	Холбогдох байгууллагын санал	21-23
	Аудитын газраас өгөх тайлбар	24

Товчилсон үгийн тайлал:

ССАЖЯ – Соёл, спорт, аялал жуулчлалын яам

ХХААЯ – Хүнс, хөдөө аж ахуйн яам

ХАХНХЯ – Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам

БСШУЯ – Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

БОНХЯ – Байгаль орчин, ногоон хөгжлийн яам

ИТХ – Иргэдийн төлөөлөгчдийн хурал

ЗДТГ- Засаг даргын тамгын газар

ЦДАШ – Цахилгаан дамжуулах агаарын шугам

ТЭЗҮ – Техник, эдийн засгийн үзүүлэлт

ХХК – Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ТБОНӨХБАҮХАТХ – Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,
ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Улс, орон нутаг, замын сангийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитыг дараах чиглэлийн хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх.
- Орон нутаг, замын сангийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх.
- Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкаас 2015 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн

Хамарсан хүрээ

Увс аймагт улс, орон нутаг, замын сангийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох эрх бүхий байгууллагуудыг хамруулан шалгалаа.

Арга зүй

Аудитын явцад холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, аймгийн Худалдан авах ажиллагааны алба, байгууллагын худалдан авах үйл ажиллагааны зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэж баталгаажуулах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулах, мэдээ судалгаанд тулгуурлан дараах ажлыг гүйцэтгэв.

- Монгол улсын 2015 оны төсвийн тухай хуульд туссан хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ ТЭЗҮ, баталгаажсан зураг төсөвтэй байсан эсэх
- Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу хийгдсэн эсэх
- Хэрэгжсэн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн техникийн хяналт үр дүнтэй байсан эсэх
- Хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжиж, бодитой дүгнэгдэж, данс бүртгэлд тусгагдан, гэрээний үүргээ хэрэгжүүлсэн эсэхийг шалгаж Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан .

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг явуулахад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримталж ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад материалыг ажлын баримтад хавсаргав.

Гүйцэтгэлийн аудитыг аймгийн Аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд хянаж удирдаж, аудитын менежер Ж.Энхжаргал аудитын стандартыг хангуулж, хянаж, зохион байгуулж, ахлах аудитор С.Алтанхундага, аудитор Т.Намжил, С.Батсайхан, ахлах шинжээч М.Батсуурь, шинжээч Я.Зунгарав нар хийж гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна

1.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар:

Увс аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Аймгийг хөгжүүлэх 2015 оны үндсэн чиглэл, нийгэм эдийн засгийн зорилтын хүрээнд салбар яамдад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт гарган хүргүүлсэн байна. Үүнд:

сая.төгрөг

Д/д	Яамны нэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015-2016 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн тоо	Мөнгөн дүн
1	Барилга хот байгуулалтын яам	11	23248.6
2	Эрчим хүчний яам	4	7050.0
3	Зам тээврийн яам	9	24544.6
4	ССАЖ-ын яам	7	16300.0
5	ЭМЯам	8	3679.0
6	ХХААЯ	9	13053.6
7	ХАХНХЯ	2	2980.0
8	БСШУЯам	19	17344.5
9	БОНХЯам	10	1628.0
10	Сангийн яам	2	5310.0
11	Хөдөлмөрийн яам	2	5270.0
12	Хууль зүйн яам	5	3699.0
13	Шадар сайд	3	1650.0
14	Засгийн газрын хэрэг эрхлэх асуудлын хүрээнд	2	7700.0
	Нийт	93	133457.3

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулиар Увс аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 37 төсөл арга хэмжээнд 34211.8 сая төгрөгийн эх үүсвэр баталжээ. Монгол Улсын 2015 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 23 төсөл арга хэмжээнд 8541.4 сая, Хөгжлийн банкны эх үүсвэрээр 10 төсөл арга хэмжээнд 19180.4 сая, нийт 33 ажил 27721.8 сая төгрөгийн эх үүсвэрийг өөрчлөн баталсан байна.

Увс аймгийн Засаг даргад төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнээс 19 төсөл, арга хэмжээний 2567.5 сая төгрөгийн эх үүсвэр эрх шилжиж ирсэн байна. 2015 онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний эх үүсвэр дараах байдлаар батлагдан санхүүжилт олгогдсон байна.

Д/д	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ	/сая төгрөгөөр/	
		2015 онд санхүүжих дүн	2015 онд олгосон санхүүжилт
1	Хархираа амралтын газрын цахилгаан дамжуулах агаарын шугам	250.0	188.8
2	Тэс сум 320 хүүхдийн Сургуулийн барилгын их засвар	474.0	454.1
3	Сагил сумын Сургуулийн дотуур байрны барилгын засвар	197.1	197.1
4	Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажил	93.3	64.6
5	Тариалан сумын Сургуулийн дотуур байрны засвар	123.2	123.2
6	Бөхмөрөн сумын 320 хүүхдийн хичээлийн байрны засвар	475.9	471.4
7	Хяргас сумын Ахлах сургуулийн барилгын засвар	24.0	
8	Тэс сумын төвийн Цахилгаан шугамын өргөтгөл	50.0	48.5
9	Зүүнхангай сумын Сургуулийн дотуур байрны гал зуухны засвар	50.0	48.0
10	Өндөрхангай сумын төвийн тохижилт	50.0	49.9
11	Цагаанхайрхан сумын төвийн Цахилгаан шугам, гүний худаг	50.0	50.0
12	Өлгий сумын төвийн тохижилтын ажил /зогсоол/	50.0	49.0
13	Давст сумын гадна тохижилтын ажил	50.0	50.0
14	Хяргас сумын төвийн тохижилт /явган зам/	50.0	47.7
15	Малчин сумын тохижилт /зам/	50.0	49.9
16	Өмнөговь сумын тохижилт /цахилгааны шугам/	50.0	49.9
17	Баруунтуруун сумын тохижилт /явган зам /	50.0	49.9
18	Ахмадын сувиллын барилга	400.0	273.4
19	Музейн шинэчлэл	30.0	30.0
	Дүн	2567.5	2295.4

Орон нутгийн болон замын сангийн хөрөнгө оруулалтын талаар:

Аймгийн ИТХ-ын 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 10/06 тоот тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар 5 төсөл, арга хэмжээнд 328.7 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 10 төсөл, арга хэмжээнд 313.5 сая төгрөг баталсан байна.

Орон нутаг, замын сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний эх үүсвэр дараах байдлаар батлагдан санхүүжилт олгогдсон байна.

		/сая төгрөгөөр/	
Д/д	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ	2015 онд санхүүжих дүн	2015 онд олгосон санхүүжилт
Орон нутгийн хөрөнгө оруулалтаар			
1	Цогцолбор 1-р сургуулийн дотуур байрны засварын дутуу	35.0	
2	Цогцолбор 2-р сургуулийн засварын дутуу	200.0	
3	Хөтөлбөрүүдэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх, үр дүнг сайжруулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах	10.0	
4	Аймгийн Татварын хэлтсийн тоног төхөөрөмж, эд хогжил худалдан авах	13.7	13.7
5	Орон сууц худалдан авах /орон нутгийн өмч/	70.0	
	Дүн	328.7	13.7
Замын сангийн хөрөнгө оруулалтаар			
1	Аймгийн хилийн зааг дээр мэдээллийн самбар 3 ширхэг, аймагаас сум, сумаас сум хоорондын	10.0	10.0

	замууд дээр чиглэлийн 10 ширхэг тэмдэг хийгдсэн ажил		
2	Улаангом хот доторхи зам арчлалт хамгаалалт нөхөөс хийх	15.0	13.8
3	Хөгжимт жүжгийн театрын өмнө талбайд 1248 м2 авто зогсоол	55.5	49.5
4	Солонго төвийн урд 312м2 авто зогсоол	13.8	11.9
5	Цагдаагийн газар 504.4м2 авто зогсоол	22.4	22.3
6	Гэр хорооллын гудамж хоорондох, Улаан уулын гүүрнээс Харзын гатлага хүртэлх зам тэгшилж сайжруулах 25км	75.8	72.4
7	Чандмань гүүр	8.0	8.0
8	Гашууны голын төмөр бетон гүүрийн засвар	48.0	48.0
9	Хот дотрохи явган хүний замын ажил	46.0	44.5
10	Солонго төвийн урд авто зогсоолын өргөтгөл	19.0	18.7
	Дүн	313.5	299.1

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 5 төсөл, арга хэмжээнд 328.7 сая төгрөг баталсан ч төсвийн орлогын төлөвлөгөө тасарсан тул 80.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

1.2. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зураг төсвийн өртгөөс нь бага төсөв батлагдсан байна.

Төсвийн тухай хуулийн 29.4-д “хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн зураг төсвөө батлуулсан хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана” гэж заасны дагуу аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн 19 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг бүрэн хийлгэсэн байна.

Монгол улсын 2015 оны төсвийн тухай хуульд тусгагдсан зарим хөрөнгө оруулалт, төсөл арга, хэмжээний ТЭЗҮ, зураг төсвөөс бага эх үүсвэр баталсанаас зураг төсөвт дахин өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Ахмадын сувиллын барилга угсралтын ажлыг 642.5 сая төгрөгөөр барихаар ТЭЗҮ, зураг төсөв хийгдсэн ч Монгол улсын 2015 оны төсвийн тухай хуулинд 400.0 сая төгрөгийн эх үүсвэр баталсан.
- Хархираа амралтын газрын 10 кВ-ын ЦДАШ, 10/0.4 кВ дэд станцын угсралтын ажлын төсвийг 494.2 сая төгрөгөөр ТЭЗҮ, зураг төсөв хийгдсэн ч Монгол 2015 оны төсвийн тухай хуульд 250.0 сая төгрөгийн эх үүсвэр баталсан.

Ахмадын сувиллын барилга угсралтын ажлын эх үүсвэрт Монгол улсын 2015 оны төсвийн тухай хуульд 400,0 сая төгрөг баталсан учир зураг тусгагдсан гадна тохижилт, торхон байрны ажлыг хасаж гүйцэтгүүлсэн байна.

Хархираа амралтын газрын 10 кВ-ын ЦДАШ, 10/0.4 кВ дэд станцын угсралтын ажлын төсвийг 494.2 сая төгрөгөөр ТЭЗҮ, зураг төсөв хийгдэж, “Нью Эрхэм” ХХК 328.6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарчээ. Тухайн төсөл арга хэмжээнд Монгол улсын 2015 оны төсвийн тухай хуульд 250.0 сая төгрөг батлагдсан тул аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 6 дугаар сарын 11-ны А/83 дугаар тогтоолоор үлдэгдэл санхүүжилт 78.6 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэн гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зураг төсвийн өртгөөс нь бага төсөв батлагдсан байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1. Монгол улсын төсвийн тухай хуулинд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний эх үүсвэрийг батлагдсан ТЭЗҮ, зураг төсвийн дагуу батлах.

БҮЛЭГ 2 *Худалдан авах ажиллагааны алба худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулжээ.*

2.1. Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтыг бүрэн хангасан байна.

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны алба улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжиж ирсэн 19, орон нутгийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар 11, нийт 30 төсөл арга хэмжээний худалдан авах ажлыг зохион байгуулсан байна.

Үүнээс улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжих 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг тухайн байгууллага нь зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны алба улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 17, замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 8, нийт 25 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар, 3 төсөл арга хэмжээг цаасаар зохион байгуулжээ.



Харьцуулалтын аргаар 9 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33.2.1 дах заалтын дагуу 3 болон


түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдсэн албан тоот хүргүүлж ажиллажээ.

Худалдан авах ажиллагааны урилгыг *e-procurement.mn*, *uvstender.mn* цахим хаяг, Увс телевиз, МВС, Увс нам бус телевиз гэсэн орон нутгийн телевиз, Өглөөний сонин, Увсын өнгө сонингоор олон нийтэд мэдээлж байсан байна.

2.2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны алба улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 30 төсөл арга хэмжээнээс 17 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер, 9 төсөл арга хэмжээнд харьцуулалтын аргаар тендерийг зохион байгуулж, 2 төсөл арга хэмжээнд шууд худалдан авах гэрээ байгуулсан байна. Худалдан авах ажиллагааны үр дүнд нээлттэй зарласан ч оролцогч ирээгүй тул Өндөрхангай сумын төвийн тохижилтын ажлыг гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсний дагуу шууд гэрээ байгуулсан байна.

Увс аймгийн хэмжээнд 2015 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг графикаар харуулбал



Монгол улсын 2015 оны төсвийн тухайн хуулинд “Түүх, дурсгал, соёлын өвийг дэмжих хөрөнгө оруулалт”-ийн эх үүсвэрээс 30,0 сая төгрөгийн санхүүжилт ирснийг аймгийн Музейд эрх шилжүүлжээ.

Худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зарласан ч оролцогч ирээгүй гэдэг шалтгаанаар “Хүдэнгийн уурхай” ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс аймгийн Татварын хэлтсийн тоног төхөөрөмж, эд хогжил худалдан авах 13,7 сая төгрөгийг тухайн байгууллагад нь эрх шилжүүлсэн байна. Татварын хэлтэс 5,0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, 8,7 сая төгрөгөөр тавилга худалдан авах ажиллагааны тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 17, замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 8, нийт 25 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар, 3 төсөлт арга хэмжээг цаасаар худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.
2. Худалдан авах ажиллагааны урилгыг цахим хаягаар мэдээлж 17 төсөл арга хэмжээг нээлттэй, 9 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 2 ажилд шууд худалдан авах гэрээ байгуулсан байна.

Бүлэг 3

Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

3.1. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гэрээний дагуу олгоогүйгээс хугацаа хэтэрсэн байна.

Увс аймгийн Засаг даргад эрх шилжсэн 19, замын сангийн хөрөнгөөр 10, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1, нийт 30 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 7 ажлын 266.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Үүнд:

сая.төгрөг

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	Дутуу олгосон Яамнаас	санхүүжилт Аймгаас
Улсын төсвийн хөрөнгө оруулалт				
1	Ахмадын сувиллын барилга	"Гончигсүм" ХХК	126.6	
2	Хархираа амралтын газрын цахилгаан дамжуулах агаарын шугам	"Нью Эрхэм" ХХК	2.4	58.8
3	Тэс сум 320 хүүхдийн Сургуулийн барилгын их засвар	"Дэглий цагаан" ХХК	18.3	1.6
4	Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажил	"Гончигсүм" ХХК	28.7	
5	Бөхмөрөн сумын 320 хүүхдийн хичээлийн байрны засвар	"Их барилга Увс" ХК	4.5	
6	Хяргас сумын Ахлах сургуулийн барилгын засвар	"Гончигсүм" ХХК	24.0	
7	Тэс сумын төвийн Цахилгаан шугамын өргөтгөл	"Сантех Увс" ХХК	1.2	
Дүн			205.7	60.4

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас өмнөх оноос шилжиж ирсэн 2 ажил 235.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Үүнд:

				сая.төгрөг
Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	2015 онд санхүүжих дүн	2015 онд олгогдоогүй санхүүжилт
Орон нутгийн хөрөнгө оруулалтаар				
1	Цогцолбор 1-р сургуулийн дотуур байрны засварын дутуу	“Скай айран” ХХК	35.0	35.0
2	Цогцолбор 2-р сургуулийн засварын дутуу	“Цагаан хөшөө трейд” ХХК	200.0	200.0
	Дүн			235.0

Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаас 4 ажлын 4.2 сая, төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Үүнд:

			сая.төгрөг	
Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	Дутуу олгосон санхүүжилт Техник хяналт	Магдлашгүй зардал
Замын сангийн хөрөнгө оруулалт				
1	Улаангом хот доторхи зам арчлалт хамгаалалт нөхөөс хийх	"Увс АЗЗА" ТӨХК	0.2	0.3
2	Гэр хорооллын гудамж хоорондох, Улаан уулын гүүрнээс Харзын гатлага хүртэлх зам тэгшилж сайжруулах 25км	"Увс АЗЗА" ТӨХК	1.3	1.3
3	Хот дотрохи явган хүний замын ажил	"Мөнхжим өргөө" ХХК	0.8	
4	Солонго төвийн урд авто зогсоолын өргөтгөл	"Тэнгэрлэг хийц" ХХК	0.3	
	Дүн		2.6	1.6

Техник хяналтын зардлын дутуу олгосон санхүүжилт 2.6 сая төгрөгийг тодруулахад аймгийн Тээвэр авто замын газар татан буугдаж холбогдох мэргэжилтэн аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст орсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хийгдсэн зарим ажлын олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэл 60.4 сая төгрөг харьяа яамдад татагдсан байна.

Мөн Хархираа амралтын газрын 10 кВ-ын ЦДАШ, 10/0.4 кВ дэд станцын угсралтын ажлын санхүүжилтийн зөрүү 78.7 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 6 дугаар сарын 11-ны А/83 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн боловч санхүүжилт олгогдоогүй байна.

Монгол улсын Иргэний хуулийн 350.1.1-д "Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх" гэж заасан нь зөрчигдсөн байна. Гэрээний хугацаа хэтэрсэн шалтгаан нь дараах байдалтай байна.

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр			Гүйцэтгэгч компани нэр	Хэтрүүлсэн хоног	Хугацаа хэтэрсэн шалтгаан
1	Малчин	сумын	төвийн	"Увс өргөө" ХХК	16	Санхүүжилт хугацаанд нь хийгээгүй
2	Өмнөговь	сумын	төвийн	"ЭДС" ХХК	92	Санхүүжилт хугацаанд нь хийгээгүй

3	Улаангом хотын төвийн зам арчлалт, хамгаалалт, нөхөөс хийх	“Увс-А33А” ТӨХК	45	Гудамж төслийн ажлаас
4	Солонго төвийн урд 312 м ² авто зогсоол	“Тэнгэрлэг хийц” ХХК	10	Газар чөлөөлөөгүй
5	Аймгийн хилийн зааг дээр мэдээллийн самбар 3 ш, аймгаас сум, сумаас сум хоорондын замуудад чиглэлийн 10 ш тэмдэг хийх	“Уран ган хийц” ХХК	66	Санхүүжилт хугацаанд нь хийгээгүй

Улсын төсвөөс 2014 онд эрх шилжиж ирээд хийгдэж дуусаагүй Завхан, Бөхмөрөн, Зүүнхангай, Өндөрхангай, Ховд, Цагаанхайрхан, Тэс сумдын тохижилтын ажлыг гүйцэтгүүлж санхүүжилт нийт 223.0 сая төгрөгийг олгосон байна.

БОНХАЖЯ-наас гэрээ байгуулан улсын төсвийн хөрөнгөөр “Солонго талст” ХХК Наранбулаг сумын нутагт 10.0 сая төгрөгөөр 5 га талбайд, “Увс экаунт” хоршоо Малчин сумын нутагт 10.0 сая төгрөгөөр 5 га талбайд тус тус ойн зурвас байгуулсан байна.

ХХАА-н яамны Мал хамгаалах сан, аймгийн Засаг дарга, “Ус эрдэнэ” ХХК-тай байгуулсан гурвалсан гэрээний дагуу аймгийн Засаг даргын 2015 оны 7 дугаар сарын 10-ны А/408 тоот захирамжаар 10 худаг гаргуулахаар шийдвэрлэснээс 5 худаг гаргасан байна.

3.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавьсан хэдий ч зарим ажлын чанар хангалтгүй, данс бүртгэлд тусгаагүй байна.

Барилгын тухай хуулийн 12.4-д “**Барилгын чанарын баталгаат хугацаа 3 жил байна**”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлд “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах **гэрээний нөхцөл** шаардлагыг тодорхой заасан” байхад захиалагчийн зүгээс гүйцэтгэгчид тавих хяналт сул, гүйцэтгэгч байгууллагууд үүргээ биелүүлэхгүй байгаа нь барилгын ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна.

Увс аймагийн Засаг даргад эрх шилжиж ирсэн зарим хөрөнгө оруулалтын ажлуудад аудитын явцад дараах зөрчил илэрснийг арилгуулахаар албан шаардлага өглөө. Тухайлбал:

- “Их Барилга Увс” ХК –ни 475.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Бөхмөрөн сумын Дунд сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрны засварын ажлыг гүйцэтгэн 2015 оны 9 сард хүлээлгэн өгсөн ч дээврийн замаск унасан, бохир усны шугам хөлдсөн, зарим нэг ангийн тааз, хананы шавардлага унаж ховхорсон



- “НББЭ” ХХК –ни 197.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сагил сумын Дунд сургуулийн дотуур байрны засварын ажлыг гүйцэтгэн 2015 оны 8 сард хүлээлгэн өгсөн ч зарим тасгийн таазны гэрэл унасан, хаалганы амалгаануудын шавардлага унасан, тааз хэсгийн турбаны шавар унасан, гал тогооны таазны шохой ховхорсон



- “Мөнхийн Ундраа Увс” ХХК –ни 49.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Давст сумын тохижилтын ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн ч 3,6 сая төгрөгийн өртөгтэй урсдаг электрон самбар хэвийн ажиллахгүй



- Хүдэнгийн уурхай ХХК-ни 123.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тариалан сумын Ахлах сургуулийн 2-р дотуур байранд их засвар хийж 2015 оны 9-р сард хүлээлгэн өгсөн ч ажлаас 38 цонхны гадна хүрээгээр дулаан алдаж цанталт үүссэний улмаас цонхны амалгааны өнгөлгөө ховхорсон



- “Увс Барилга” ХХК–ни Зүүнхангай сумын тохижилтын ажлын хүрээнд 48,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ахлах сургуулийн гал тогооны засварын ажлыг 2015 оны 10 сард хүлээлгэн өгсөн ч таазны шохой унах, хананд цууралт үүссэн, зарим пускател, розетка, цахилгааны ачааллаа даахгүйн улмаас шатсан, хаалганы шавардлага унах, нугас эвдэрсэн



- “Гончигсүм” ХХК-ни 93.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлыг 2015 оны 8 сард хүлээлгэн өгсөн ч бохирын шугам шаардлага хангахгүйн улмаас хөлдөлт үүсч 00-ын өрөөний суултуур, гар угаалтуурын ус шугамаараа гүйхгүй халих, крантууд эвдэрсэн



- “Дэглий цагаан” ХХК-ни 474.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тэс сумын Ахлах сургуулийн 320 хүүхдийн хичээлийн барилгын засварын ажлыг 2015 оны 9 сард хүлээлгэн өгсөн ч хаалганы хүрээ эвдэрсэн, цонх хагарсан, гэрэл унасан, будаг

ховхорсон, шавар унасан, спорт заалны самбар хөндийрсэн, хуучин анги бүрт байсан цэвэр усны холболт байхгүй болсон



- “Хүдэнгийн уурхай” ХХК-ни 30.0 сая төгрөгийн өртөгтэй Музей шинэчлэл “Түүх, дурсгал, соёлын өвийг дэмжих хөрөнгө оруулалт”-ийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтонд заасан ажлаас байгалийн танхим, шашны танхим, орчин үеийн танхим засварлах, дэглэх ажлуудыг гүйцэтгээгүй



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн орон нутагт эрх шилжиж ирээгүй хөрөнгө оруулалтын ажлуудад аудитын явцад дараах зөрчил илэрснийг арилгуулахаар албан шаардлага өглөө. Тухайлбал:


- Цэлмэг ази констракшин ХХК-ни 983.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Өмнөговь сумын 75 хүүхдийн ортой Цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг 2015 оны 12 сард хүлээлгэн өгсөн ч зарим ажил дутуу хийгдсэн, эвдрэл гэмтэл гарсан



- Улсын төсвөөс 1367.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Тэс сумын Соёлын төвийн 2015 оны 10 сард хүлээлгэн өгсөн барилга угсралтын ажлаас гадна хананд цууралт өгсөн, зарим хаалганы түгжээ, бариул хугарч, эвдэрсэн, хаалганы хүрээ унасан



- Улсын төсвөөс 801.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Тэс сумын төвийн шинэчлэлтийн ажлын хүрээнд хийсэн Нутгийн удирдлагын ордны барилга угсралтын ажлаас ОО-ийн өрөөний шал суулт өгч, плита хагарсан, суултуур, угаалтуур өргөгдсөн



Зүүнговь сум орон нутгийн давсан орлогоос ЗДТГ-ын хуучин барилгын халаалтын засварын ажлыг 2.5 сая төгрөгөөр хийсэн боловч техникийн тодорхойлолтод заасны дагуу халаалтын системийг гүйцэтгээгүй нь аудитын явцад илэрснийг арилгуулахаар албан шаардлага өглөө.



Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт дээрх зөрчлүүдийг арилгуулах талаар албан тоот, албан шаардлагыг хүргүүлэв.

Сангийн сайдын 2012 оны 10 дугаар сарын 27-ны 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 5.1-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламж, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр нь тухайн төсөвт байгууллагын тайлан балансад бүртгэнэ” гэж заасныг зөрчин дараах хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаагүй байсан зөрчлийг арилгуулахаар албан шаардлага тогтоолоо. Үүнд:

- Тэс сумын төвийн шинэчлэлтийн ажлын хүрээнд хийгдсэн явган хүний зам 57.6 сая
- Тэс суманд шинээр гаргасан 2 худаг 30.6 сая
- Гашууны голын гүүрийн засвар 48.0 сая
- Хяргас сумын Ахлах сургуулийн барилгын засварын ажил 24.0 сая
- Музей шинэчлэл “Түүх, дурсгал, соёлын өвийг дэмжих хөрөнгө оруулалт”-ийн ажил 26.0 сая

Мөн зарим байгууллагууд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг данс бүртгэлд тусгаагүй байсныг аймгийн Аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитын явцад данс бүртгэлд нэмж тусгуулж залруулга хийлгэсэн. Тухайлбал:

- Баруунтуруун сумын дулааны шугамын 150.0 сая, сумын тохижилт 49.9 сая төгрөг
- Өмнөговь сумын цахилгаан шугам сүлжээ 49.9 сая
- Цагаанхайрхан сум цахилгаан шугам сүлжээ, гүний худаг 49.9 сая
- Зүүнхангай сумын Ахлах сургуулийн дотуур байр, гал зуухны засварын ажил 48.0 сая
- Давст сумын тохижилт 49.9 сая
- Малчин сумын тохижилт 49.9 сая

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн 7, орон унтгийн төсвийн 2, замын сангийн 4, нийт 13 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид санхүүжилтийг дутуу олгосон байна.
2. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.
3. Хөрөнгө оруулалтын зарим ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

Аймгийн Засаг дарга Д.Цэндсүрэнд

1. Сангийн сайдын баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ыг мөрдөж ажиллах.

Холбогдох байгууллагын санал


**УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД**
213400, Улаангом сум, Увс аймаг
Регистр: 9062858 ш/х: 267
Утас/факс: 70452113

2016.04.20 № 135

танай _____ -ны № _____ -тоот _____

**УВС АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан, дүгнэлттэй танилцлаа.

ИТХ-ын зүгээс оруулах санал байхгүй болно.

ДАРГА  ЧЧИМЭД




УВС АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
213400, Улаангом, Увс аймаг
Утас|Факс: 7045-2012

2016.04.20 № 8/346
танай _____-ны № _____-т


АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Бүлэг бүрт өгөгдсөн дүгнэлт, зөвлөмжтэй санал нэгдэж байна. Ингээд дараах саналыг хүргүүлж байна.

Үүнд:

1. Аудитын тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн бүх гишүүдэд танилцуулж, санал авч байх,
2. Аймгийн ОНХС-ийн санхүүжилт батлагдсанахаа дараа сүүлийн 3 жил доголдож, улсын хэмжээгээр дутуу санхүүжигдэж, зарим хийгдсэн ажлын санхүүжилт 2015, 2016 он дамнан хугацаа алдсаар байгаа. Энэ нь тухай ажлыг банкны өндөр хүүтэй зээл авч гүйцэтгэсэн дотоодын компаниудад маш хүнд дарамт болж байгаа байдлыг нотлох баримттайгаар ялангуяа Сангийн яаманд уламжлах,
3. Санхүүжилт хугацаа алдаж сунжрах нь цаанаа гэрээ зөрчих, гэрээг дүгнэх үндэслэлгүй болох, эцэстээ гүйцэтгэл, чанарт муугаар нөлөөлж байгааг бас уламжлахыг санал болгож байна.

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  3. ГАНБОЛД

2 590

07040107

My:doctamglin gazar -A5



**УВС АЙМАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
АЛБА**

4010051, Увс аймаг, Улаангом сум,
Утас/факс: 70453232

2016.04.20 № 16
танай _____ -ны № _____ -тоот

УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Увс аймагт улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан дүн, дүгнэлт, зөвлөмжтэй танилцлаа. Худалдан авах ажиллагаатай холбоотой санал дүгнэлттэй санал нэг байгаа болно.

ДАРГА  Л.ЦОГТСАЙХАН

Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналын хариу.

- Аймгийн ИТХ-ын ирүүлсэн саналд:

Тайлангийн төсөлтэй санал нэг байна гэсэн албан тоот ирсэн тул хариу тайлбар өгөх шаардлагагүй.

- ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтсийн ирүүлсэн саналд:

- Аудитын тайлангийн төслийг аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох хэлтэс, агентлагт танилцуулж санал авч тайланг эцэслэсэн хүргүүлдэг тул Засаг даргын зөвлөлийн гишүүдэд танилцуулан төсөлд санал ирүүлэх нь нээлттэй болно.
- Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад аймгийн Аудитын газраас нийцлийн аудит хийж байгаа тул тухайн аудит тайланд тусгагдах болно.
- Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний санхүүжилтийн хугацаа хоцорч, он дамжиж байгаа талаар тайланд тодорхой дурдсан бөгөөд холбогдох зөвлөмжийг өгсөн болно.

- Аймгийн Худалдан авах ажиллагааны албаны ирүүлсэн саналд:

Тайлангийн төсөлд тусгагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой дүгнэлттэй санал нэг байна гэсэн тул хариу тайлбар өгөх шаардлагагүй.

ТАЙЛАН БИЧСЭН: АХЛАХ АУДИТОР

АХЛАХ ШИНЖЭЭЧ
АУДИТОР

ШИНЖЭЭЧ

С.АЛТАНХУНДАГА

М.БАТСУУРЬ
Т.НАМЖИЛ
С.БАТСАЙХАН
Я.ЗУНГАРАВ